



БАТЛАВ.



**ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН ИХ ЗАСВАР /ХӨВСГӨЛ, ЦАГААН-ҮҮР СУМ/  
ХИЙХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар № БШУЯ/202102171/1.4.2

Хөвсгөл аймаг

**НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Нэг талаас *Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.ИДЭРБАЯСГАЛАН* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 7 дугаар багт байршилтай “Бунбах” ХХК-ийн захирал Д.ДАРЬБААТАР* (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1.1 “Иргэний хууль”, “Барилгын тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2 Захиалагч нь *Цэцэрлэгийн барилга /Цагаан-Үүр сум/ БШУЯ/202102171 /1.4.2 дугаартай гэрээт ажлыг-г* (цаашид “ажил” гэх) *73,818,653 (Далан гурван сая найман зуун арван найман мянга зургаан зуун тавин гурван)* төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

1.3 Гэрээний нийт дүн: *73,818,653 (Далан гурван сая найман зуун арван найман мянга зургаан зуун тавин гурван)* төгрөг. Үүнээс :

Санхүүжилтийн эх үүсвэр: **Улсын төсвийн хөрөнгө оруулалт**

2021 онд: *73,818,653 (Далан гурван сая найман зуун арван найман мянга найман мянга зургаан зуун тавин гурван)* төгрөг;

1.4 Гүйцэтгэгч нь *Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр суманд байршилтай Цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг* 2021 оны 5 дугаар сарын 01-ны өдөр эхэлж, 2021 оны 08 дугаар сарын 01-ний өдөр ашиглалтад оруулна.

1.5 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний бичиг баримт” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендер;


Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;


Техникийн тодорхойлолт;

Зураг

Захиалагчийг төлөөлж: \_\_\_\_\_



Гүйцэтгэгчийг төлөөлж: \_\_\_\_\_













тодорхойлолтыг хангахааргүй материалыг ашигласан зэрэг нь эрх бүхий албан тушаалтны дүгнэлтээр тогтоогдсон

3.3 Гүйцэтгэгч гэрээний үүрэг, захиалагчийн болон эрх бүхий хяналт шалгалтын байгууллагын дүгнэлт албан шаардлагыг биелүүлээгүй, гэрээний үүргээ зөрчсөн, эсхүл захиалагчаас хүлээн авсан ажлын талбай, барилга байгууламжийг учирч болох эрсдлээс хамгаалах, зүй зохистой ашиглах арга хэмжээ аваагүй, гэрээний үүргээсээ өөрөө татгалзсан зэрэг тохиолдолдлууд,

### ДӨРӨВ. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

4.1. Гэрээг 5 хувь үйлдэж захиалагч тал гурав, гүйцэтгэгч тал 2 хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдөр гэрээ хүчин төгөлдөр болно.

4.2 Сангийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 125 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “ажил худалдан авах ажиллагаа”-ны тендерийн жишиг баримт бичгийн гэрээний ерөнхий нөхцөл болон энэ гэрээний 1.5 дахь хэсэгт заасан баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3 Энэхүү гэрээний нөхцөлд гэрээнд заасан ажлын тоо хэмжээ, үнэ өөрчлөхөөс бусад асуудлаар гэрээнд өөрчлөлт оруулж болох бөгөөд уг уг өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

4.4 Энэхүү гэрээ нь гэрээг цуцалснаас бусад тохиолдолд “Барилгын тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг заасан хугацаа дуусах өдөр хүртэл хүчинтэй байна.

### ТАВ. ГЭРЭЭ ДҮГНЭХ

5.1 Захиалагчийн төслийн баг болон гүйцэтгэгч байгууллага хамтран ажил гүйцэтгэх гэрээг дүгнэнэ.

5.2 Барилга угсралтын ажлын үндсэн гэрээ болон нэмэлт гэрээг тухайн үе шатанд хийгдсэн ажлын гүйцэтгэл, гэрээний бусад нөхцлийг үндэслэн дүгнэнэ.

5.3 Барилгын ажлын гүйцэтгэл бүрэн дууссан тохиолдолд захиалагч, гүйцэтгэгч, ашиглагч, зохиогч хамтран уг барилга багууламжид үзлэг шалгалт хийсэн тухай техник хяналтын нэгдсэн дүгнэлт болон Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан баримт бичгийг захиалагчаас аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлнэ.

5.4 Байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах асуудлыг аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар зохион байгуулна.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН  
НИЙГМИЙН БОДЛОГЫН  
ХЭЛТЭСИЙН ДАРГА

  
С.НАРАНТУЯА

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,  
Аймгийн ЗДТГ-ын “А” байр  
Утасны дугаар: 99568811

#### ХЯНАСАН:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ДАРГА

  
Б.БОЛД

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,  
Аймгийн ЗДТГ-ын “А” байр  
Утасны дугаар:  
70388821

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“БУНБАХ” ХХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

  
Б.БАТСАЙХАН

Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 7  
угаар баг  
Утас: 99993240, 99998923  
Харилцагч банкны нэр: Хас банк,  
Дансны дугаар: 5000132343  
Регистрийн дугаар: 2705362

ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗРЫН ДАРГА

  
Б.ДОЛЖИНСОРОГДОГ

Захиалагчийг төлөөлж:

Гүйцэтгэгчийг төлөөлж:



## НЭГ. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Гэрээний ерөнхий нөхцлийн дугаар	Гэрээний тусгай нөхцлийн заалтууд
ГЕН 1.1	Захиалагч: <i>Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөвсгөл, Мөрөн сум, 8-р баг, Аймгийн ЗДТГ-ын байр</i>
ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар нь <i>Цэцэрлэгийн барилгын их засвар /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/ хийх ажил гүйцэтгэх гэрээ</i> <b>БШУЯ/202102171/1.4.2</b>
ГЕН 3.1	Төслийн менежер: <i>Ц.Ганзориг, Аймгийн ГХБХБ газрын дарга.</i>
ГЕН 3.2	Төслийн менежер нь гэрээний ажлын үе шатны хуваарьт заасны дагуу шинэ үе шатны ажил эхлэх, дуусах тухай бүрт ажлын талбайд ажиллаж, ажлын гүйцэтгэл, ил далд ажлын актыг баталгаажуулж, гүйцэтгэгчтэй уулзах уулзалтын тэмдэглэлийг үйлдэж, уг тэмдэглэлийн хувийг уулзалтад оролцсон хүмүүст болон захиалагчид хүргүүлнэ. Хийгдэх арга хэмжээнд талуудын хүлээх үүрэг хариуцлагыг төслийн менежер уг ажлын уулзалтан дээр, эсхүл түүний дараа шийдвэрлэж, энэ тухай ажлын уулзалтад оролцсон бүх этгээдэд зааварчилгаа өгөх мэдэгдлийг хүргүүлнэ.
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: <i>2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: <i>2020 оны 08 дугаар сарын 01-ний өдөр</i>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор төслийн менежерт хүргүүлж батлуулна.
ГЕН 7.1	Ажлын хөтөлбөрийг 30 хоног тутам тодотгох бөгөөд ажлын тодотгосон хөтөлбөрт үйл ажиллагаа бүрийн явц, үр дүн, тэдгээрийн үлдэж буй ажлыг гүйцэтгэх хугацаанд үзүүлэх нөлөө болон үйл ажиллагааны дараалалд оруулсан аливаа өөрчлөлтийг тусгана.
ГЕН 7.1	Тодотгосон ажлын хөтөлбөрийг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд суутгах үнийн дүн нь: <i>Тодотгосон ажлын хөтөлбөрийг хугацаа хоцроож ирүүлсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,01 хувьтай тэнцэх алдангийг захиалагч суутгана.</i> байна.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 365 хоног байна.
ГЕН 9.1	Ажил эхэлсэн өдрөөс чанарын баталгаат хугацаа дуусах хүртэл буюу “Барилгын тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.6 дахь хэсэгт заасан хугацаанд гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас, эсхүл дутуу орхисноос үүдэн барилга, байгууламж, хийц бүтээц, засал, тоног төхөөрөмжид гарсан алдагдал, эвдрэл, гэмтэл, чанаргүй гүйцэтгэлийг гүйцэтгэгч өөрийн зардлаар засварлана
ЕН 11.0	Төслийн менежерийн шаардсан болон үе шатны ажлын хуваарьт заасан ажил хугацаандаа хийгдээгүй тохиолдолд гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор төслийн менежерээр батлуулсан байна. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
ГЕН 12.0	Ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, урьдчилан төлөвлөх боломжгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд Төслийн менежер ажлын аль нэг үйл ажиллагааны эхлэл, эсхүл явцыг хойшлуулах зааварчилгааг гүйцэтгэгчид өгч гэрээний хугацааг сунгах эрхтэй. Гүйцэтгэгчийн буруутай үйл

Захиалагчийг төлөөлж:

Гүйцэтгэгчийг төлөөлж:



	ажиллагааны улмаас үе шатны хуваарьт заасан ажил хойшилсон тохиолдолд гэрээний хугацааг сунгаж өөрчлөхийг хориглоно.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,07 хувь байна. Гүйцэтгэгч ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хойш хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,07 хувьтай тэнцэх алдангийг 7 захиалагчид төлөх ба алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй. Энэхүү алданги нь үе шатны ажлын хуваарьт заасан ажил гүйцэтгэх хугацаанд нэгэн адил хамаарна. Гүйцэтгэгчид олгох санхүүжилтийн дүнг алдангийн хэмжээгээр бууруулан олгоно.
	Гүйцэтгэгчид олгох санхүүжилтийг хугацаа хоцроосон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,07 хувьтай тэнцэх алдангийг захиалагчаас гүйцэтгэгчид төлөх бөгөөд алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй. Гүйцэтгэгчид алданги төлөх тохиолдолд гэрээний төлбөрийг алдангийн хэмжээгээр нэмэгдүүлнэ. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүжилт саатснаас үүсэх алдангийг захиалагч хариуцахгүй.
ГЕН 15 Гэрээ дүгнэх	Гэрээг захиалагч, гүйцэтгэгч хамтран дүгнэж, ажлын гүйцэтгэл, үр дүн, уг төслөөс ашиг хүртэгч иргэдийн сэтгэл ханамжийг үндэслэн "Гүйцэтгэгч"-ийн ажлын гүйцэтгэл "Маш сайн" үнэлгээтэй бол "Ногоон", ажлын гүйцэтгэл "Сайн буюу дундаж" үнэлгээтэй бол "Шар", ажлын гүйцэтгэл "Хангалтгүй" үнэлгээтэй бол "Хар" хуудсанд тус тус бүртгэнэ
ГЕН 16.1 Эцсийн тооцоо	Төлбөр хийх хугацаа нь төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш [30]3 хоног байна. Гэрээний төлбөрийг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний санхүүжилт олгох журам" болон аймгийн Засаг даргын 2020 оны А/229 дүгээр захирамжаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний санхүүжилтийг зохицуулах журам"-д заасан баримт бичгийн бүрдүүлбэрийг тус тус үндэслэн санхүүжүүлнэ.
ГЕН 17.1	<b>Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 2021-08-01-ний дотор гаргаж өгнө.</b> Далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан актыг тухайн үе шатны ажил дуусан өдрөөс хойш [огноо]-ны дотор гаргаж өгнө. Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [огноо]-ны дотор гаргаж өгнө. Ил далд ажлын акт, технологийн тоног төхөөрөмжийн туршилтын актыг тухайн чиглэлийн инженерийн хангамжийн байгууллагын төслийн баг дахь төлөөлөл, зохиогч тус тус баталгаажуулж, төслийн менежерт тайлагнана.
	<b>Гүйцэтгэлийн зургийг 2021-08-01-ний дотор гаргаж өгнө.</b> Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ил далд ажлын акт, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт, ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг тогтоосон хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ гэрээний үнийн 5 хувьтай тэнцүү байна.
ГЕН 18.0	Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээний ерөнхий нөхцлийн 18.2 дахь хэсэгт заасан ноцтой зөрчил болон дор дурьдсан ноцтой зөрчлийг гаргасан гэж үзвэл гэрээг үл маргах журмаар цуцлах эрхтэй. Үүнд: 1. Барилга, байгууламжийн ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй буюу ажилд стандарт, захиалагчийн техникийн тодорхойлолтод зааснаас өөр чанаргүй материал бүтээцийг ашигласан, стандарт, норм ба дүрэм захиалагчийн техникийн тодорхойлолтыг хангаагүй тоног төхөөрөмж, бараа, материалыг нийлүүлсэн нь эрх бүхий этгээдийн дүгнэлтээр тогтоогдсон бол Иргэний хуулийн 355 дугаар зүйлийг үндэслэн захиалагч гэрээг цуцлана. 2. Үе шатны ажлын хуваарьт заасан заасан ажлыг удаа дараа 5-аас дээш хоногоор хугацаа хоцроон гүйцэтгэсэн, ил далд ажлын болон технологийн тоног төхөөрөмж,

3 Энэ хугацаа 3 сараас илүүгүй байна.

Захиалагчийг төлөөлж: \_\_\_\_\_

Гүйцэтгэгчийг төлөөлж: \_\_\_\_\_



	<p>шугам сүлжээний туршилтын актыг төслийн менежерээр батлуулаагүй, нөхөн бүрдүүлсэн нь тогтоогдсон</p> <p>3. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч болон хяналт шалгалтын байгууллага, төслийн менежерээс өгсөн албан шаардлага, дүгнэлт, үүрэг даалгаварыг удаа дараа хэрэгжүүлээгүй.</p> <p>4. Зураг, төсөл, техникийн нөхцлийг мөрдөөгүй</p> <p>5. Гэрээний хугацаа дуусгавар болсон</p> <p>6. Гүйцэтгэгч санхүүжилтээр олгосон гэрээний төлбөрийг зориулалт бусаар зарцуулах эрхгүй бөгөөд гэрээний төлбөрийн санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан нь тогтоогдсон</p>
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын "0" хувиар тооцно.
Онцгой анхаарах асуудал	<p>Барилгын ажил гүйцэтгэхэд дараах асуудалд онцгой анхаарал тавьж ажиллах шаардлагатай: Үүүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Модон хийц, эдлэлийн ажлыг гүйцэтгэхдээ зөвхөн стандартын шаардлагын дагуу хатааж, бэхжүүлсэн модон материал хэрэглэнэ.</li> <li>- Гэрээ байгуулах үед ажлын зурагт заасан альбом, катлогуудыг нэг бүрчлэн иж бүрдүүлж, техникийн баримт бичгийг бүрэн төгс болгосон байна.</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан бие засах газар, шат, тэргэнцэрийн зам, пандус, хийх зэрэг арга хэмжээг зураг төсөл болон төслийн экспертүүдээс гаргасан зөвлөмжийн дагуу гүйцэтгэнэ.</li> <li>- Гал түймрийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг зураг төслийн дагуу барилга, байгууламжид суурилуулсан байх</li> </ul>

### ХОЁР. ЗАХИАЛАГЧ (ТӨСЛИЙН БАГИЙН)-ИЙН ЭРХ ҮҮРЭГ

2.1 Захиалагч нь "Барилгын тухай" хуулийн 37 дугаар зүйл, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1 дэх хэсгүүдэд заасан үүрэг болон Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлнэ.

2.2 Барилга байгууламжийн үндсэн ажилд хэрэглэсэн материал, бүтээцийн чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг итгэмжлэгдсэн лабораторид нууцалсан дугаар бүхий дээж өгч тодорхойлуулах, материалын гарал үүсэл, тохиролын гэрчилгээг хянах замаар үнэлэлт дүгнэлт гаргах, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, барилгын ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн актуудыг баталгаажуулах:

2.3 Барилгын үйл ажиллагаанд холбогдох барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж, холбогдох зардлыг хариуцах,

2.4 Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гарсан хохиролыг хариуцах,

2.5 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг батлагдсан зураг төсөл, норм, дүрэм техникийн нөхцөлийг зөрчиж, чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн, чанарын шаардлага хангахгүй материал бүтээцийг ашигласан Мэргэжлийн хяналтын болон эрх бүхий байгууллагаас хийсэн үзлэг, шалгалтын дүн, техникийн дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчил гологдлыг арилгаагүй тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн зардлаар засуулах, нөхөн хийлгэх, санхүүжилтийг зогсоох, учирсан хохирлыг төлүүлэх, гэрээг цуцлах

2.6 Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг дүгнэх, барилга, байгууламж, ажил үйлчилгээг ашиглалтад хүлээн авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах.

Захиалагчийг төлөөлж: \_\_\_\_\_

Гүйцэтгэгчийг төлөөлж: \_\_\_\_\_



2.7 Чанарын баталгааны хугацаанд тухайн бараа, ажил, үйлчилгээнд зөрчил, гологдол, эвдрэл гараагүй болон зөрчил гологдлыг арилгасан тухай захиалагчийн томилсон ажлын хэсгийн дүгнэлт, захиалагчийн мэдэгдлийг үндэслэн барьцаа хөрөнгийг чөлөөлж, гүйцэтгэгчид олгох.

2.8 Төслийн менежер нь ажил худалдан авах гэрээний хэрэгжилтийн явцын талаарх дараах мэдээллийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт улирал бүрийн дараа сарын 01-ний өдөрт багтаан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

- гэрээний тусгай нөхцөлд дурдсан голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчний мэдээлэл

- Ажил худалдан авах гэрээний хэрэгжилтийн явц, үр дүн, гэрээ дүгнэсэн акт

- Ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг, үе шатны ажлын гүйцэтгэл

- Барилгад ашигласан материал, хийц, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, дүгнэлт, гарал үүслийн гэрчилгээ

- Барилгын талбайд ажиллаж байгаа инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдын судалгаа

- Зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлт,

- Барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг төсөл

- Захиалагчийн барилга техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт

- Тоног төхөөрөмж угсарсан актууд, холбогдох байгууллагаар баталгаажуулсан тоног төхөөрөмжийн туршилтын баримт бичиг, туршилт тохируулгын акт

- Санхүүжилтийн талаарх мэдээлэл

- Бусад шаардлагатай мэдээлэл

2.9 Тендерт өгөгдсөн ажлын тоо хэмжээ, захиалагчийн зөвшөөрсөн ажлын тоо хэмжээнээс гадна нэмэлтээр хийсэн ажлыг санхүүжүүлэхгүй.

2.10 Захиалагчийн санхүүжилтээр олгогдсон хөрөнгийг өөр зориулалтаар ашиглах, барилга угсралтын ажлын зураг төсвийг зохиогчийн дүгнэлт, захиалагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөн гүйцэтгэх, гэрээний нөхцөл, төсөв, норм дүрмийг зөрчиж ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэх, гарал үүсэл, тохиролын гэрчилгээгүй материал, хийц бүтээцийг ашигласан, мэргэжлийн байгууллагуудын зүгээс тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд захиалагч санхүүжилтийг зогсоох, гүйцэтгэгчээс татгалзах, гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах хүртэлх арга хэмжээг авч, учирсан хохирлыг төлүүлэх эрх эдэлнэ.


2.11 Төслийн менежер нь барилгын ажил дууссны дараа ашиглагч, гүйцэтгэгч, зохиогч, зөвлөхийг тус тус оролцуулан тухайн барилга байгууламжид үзлэг шалгалт хийж, захиалагчийн техник хяналтын нэгдсэн дүгнэлт гарган, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлтийн хамт аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хүргүүлнэ.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ


3.1 Гүйцэтгэгч нь “Барилгын тухай” хуулийн 40 дүгээр зүйл, Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1 дэх хэсгүүдэд заасан үүргийг хэрэгжүүлж, барилгын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажил эхлэх зөвшөөрөл авах, барилгын ажлын талбайд гал, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны горимыг мөрдөх, хөдөлмөр хамгааллын дэглэмийг сахиулах, гуравдагч этгээдийг барилгын ажлаас шалтгаалсан болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, байгаль орчин, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, ажлын явцад эвдэлсэн зам талбай, ногоон байгууламжийг нөхөн сэргээх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2 Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд дурдсан голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчнийг, эсхүл төслийн багаас зөвшөөрсөн бусад ажиллах хүчнийг ажиллуулна. Тендерт ирүүлсэн голлох мэргэжилтний хуваарьт заасан ажиллах хүчнийг өөрчлөх шаардлага гарвал энэ тухай хүсэлтийг төслийн багт гаргаж шийдвэрлүүлнэ.

Захиалагчийг төлөөлж: \_\_\_\_\_



Гүйцэтгэгчийг төлөөлж: \_\_\_\_\_





3.3 Барилгын ажлыг магадлал хийгдсэн, баталгаажсан зураг төсөл, норм нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих, ил далд ажлын акт, үе шатны ажлын тэмдэглэл, үе шатны ажлыг гэрээнд заасан хугацаанд багтаан гүйцэтгэж, гүйцэтгэлийг захиалагчаар батлуулах, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, ажлын явцад илэрсэн гологдол, зөрчлийг тухай бүрт нь арилгаж, буруу, дутуу хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр нөхөн гүйцэтгэх, барилгын ажлын гүйцэтгэлийн баримт бичиг, архивыг хууль журмын дагуу бүрдүүлж захиалагч болон Төрийн архивт хүлээлгэн өгөх зэрэг чиг үүргийг гүйцэтгэгч хүлээнэ.

3.4 Далд ажлын актыг тухайн ажлыг хийж дуусмагц захиалагчийн хяналтын мэргэжлийн инженерт газар дээр нь тухай бүр үзүүлж батлуулах

3.5 Барилгын ажил ашиглагдаж байгаа материал, бүтээцийн лабораторийн шинжилгээ, сертификат, тохиролын гэрчилгээг барилгын талбайд байлгах, угсралт, суурилуулалтад оруулахаас өмнө захиалагчаар хянуулж, холбогдох зөвшөөрлийг авсан байна.

3.6 Гүйцэтгэгч компаний товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний нэр, гэрээний үнийн дүн санхүүжилтийн хуваарь, ажил, эхлэх, дуусах хугацаа бүхий мэдээллийн самбарыг тухайн объектийн байрлах газарт олон нийтэд үзэгдэхүйцээр уг ажил, үйлчилгээний чанарын баталгаат хугацааны туршид заавал байршуулна.

3.7 Барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн тохиолдолд гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж захиалагч, зохиогчоор батлуулах

3.8 Гүйцэтгэгч нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд ажлын байргүй, бага орлоготой өрх иргэнээс тодорхой хэсгийг ажлын байртай болгохыг эрмэлзэж, ажлын байртай болгосон иргэдийн судалгаа, тэндэнд олгосон цалин хөлсний мэдээллийг захиалагчид ирүүлнэ.

3.9 Барилга, байгууламж, ажил, үйлчилгээг ашиглалтанд хүлээн авах, болон туршилт тохируулга хийсэн тухай акт зэрэг баримт бичиг албан ёсоор баталгаажуулахгүй, барилга байгууламжийн ашиглалтад хүлээн авах тухай шийдвэр гараагүй байх хугацаан дахь тухайн барилга, байгууламжийн ашиглалт үйлчилгээтэй холбоотой урсгал зардлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН  
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА,

 Б.ДОЛЖИНСОРОГДОГ

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,  
Аймгийн ЗДТГ-ын "А" байр  
Утасны дугаар: 99058438  
70388849

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“БУНБАХ” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕР

 Б.БАТСАЙХАН

Хөвсгөл аймаг, Мөрөн сум  
7 дугаар баг  
Утас: 99993240, 99998923

Захиалагчийг төлөөлж: \_\_\_\_\_

Гүйцэтгэгчийг төлөөлж: \_\_\_\_\_




АЖИЛ, МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ ХИЙЦИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Бараа материал, бүтээц хийцийн нэр	х/н	Тоо	Нийт үнэ	Тавигдах шаардлага стандарт	Нийлүүлэгч
1	Суултуур	иж	4	575 520	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
2	Радиаторын секц	ш	115	1 667 500	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
3	Хулдаас	М2	439.72	3 957 498	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
4	Хулдаас наах түрхлэг	кг	129.33	323 325	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
4	Хоолой д-25мм	м	245.	624 760	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
5	Хөвөө мод	м	478.5	622 077	МУ-ын стандартад нийцсэн	Монгол улс
6	Цаасан зүлгүүр	М2	60	270 012	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
7	Шохой	тн	6.2	1 851 300	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
8	Шаваас	тн	944.5	330 573	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
9	Эмалийн будаг	кг	38.5	192 160	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
10	Базаалт хөвөн хавтан	М2	281.6	5 913 348	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
11	Бэхэлгээ сэрээ	ш	558	501 840	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
12	Бүрээстэй хөнгөн цагаан утас	м	247.3	136 017	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
13	Галаас хамгаалах мөнгөлөг будаг	кг	1099.5	5 497 374	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
14	Ган хоолой д-25мм	м	80.8	269 387	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
15	Ган яндан хоолой ф-40мм	м	22.3	119 461	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
16	Ган яндан ф-50мм	м	24.2	164 754	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
17	Дефлектор	ш	6	167 760	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
18	Корунда будаг	кг	80.6	2 014 790	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
19	Маажин	кг	88.4	132 612	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
20	Өнгийн тосон будаг	кг	40.3	141 035	МУ-ын стандартад нийцсэн	БНХАУ
21	Үртэс	М3	56.1	392 700	МУ-ын стандартад нийцсэн	Монгол улс

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН  
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА,

  
Б.ДОЛЖИНСОРОГДОГ

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,  
Аймгийн ЗДТГ-ын "А" байр  
Утасны дугаар: 99058438  
70388849

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“БУНБАХ” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕР

  
Б.БАТСАЙХАН

Хөвсгөл аймаг, Мөрөн сум  
7 дугаар баг  
Утас: 99993240, 99998923

Захиалагчийг төлөөлж:

Гүйцэтгэгчийг төлөөлж:



БНУЯ/20210217/1-4-2

дугаартай пэрээний 4 дүгээр хавсралт

**АЖЛЫН ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ**

Хөвсгөл аймаг Цагаан-Үүр сум Цэцэрлэгийн засварын ажил

№	Хийгдэх ажил	Он, сар			2021 оны 06-р сар			2021 оны 07-р сар			дүн
		10 хоног	1	2	3	1	2	3			
1	Корунда будгаар шал будах	төлөвлөгөө	1 759 163							1 759 163	
		гүйцэтгэл									
2	Хулдаас нааж шал хийх	төлөвлөгөө	7 789 543	1 678 498						9 468 041	
		гүйцэтгэл									
3	Гадна хана базалтаар дулаалах	төлөвлөгөө		7 897 528	1 380 574					9 278 102	
		гүйцэтгэл									
4	Хучилтын термолиттой шавар зуурмагаар дулаалах	төлөвлөгөө		5 956 483						5 956 483	
		гүйцэтгэл									
5	Радиатор угсрах	төлөвлөгөө			8 712 573					8 712 573	
		гүйцэтгэл									
6	400мм голчтой дефлектор угсрах	төлөвлөгөө			654 502					654 502	
		гүйцэтгэл									
7	Хүүхдийн шээлтүүр байрлуулах	төлөвлөгөө			939 870					939 870	
		гүйцэтгэл									
8	Халаалтын ган яндан хоолойнууд угсрах	төлөвлөгөө			1 515 850					1 515 850	
		гүйцэтгэл									
9	Фланц байрлуулах	төлөвлөгөө			446 745					446 745	
		гүйцэтгэл									
10	Далд залгуур тавих, цахилгааны утас сүвлэх, хуванцар хоолой түүдүүлдэж тавих, ховил гаргах	төлөвлөгөө				3 000 223				3 000 223	
		гүйцэтгэл									

Захиалагчийг төлөөлж: \_\_\_\_\_



Гүйцэтгэгчийг төлөөлж: \_\_\_\_\_





11	Хана, таазыг эмалиар будах	төлөвлөгөө				14 862 549	8 404 822	23 267 371
		гүйцэтгэл						
12	Анги, унтлагын өрөөний шалыг резинэн будгаар будах	төлөвлөгөө					1 560 252	1 560 252
		гүйцэтгэл						
13	Анги, унтлагын өрөөний ханыг корунда будгаар будах	төлөвлөгөө					1 759 163	1 759 163
		гүйцэтгэл						
14	Захиалагчийн хяналтын зардал	төлөвлөгөө	173 246	281 880	247 778	324 528	180 810	1 240 122
		гүйцэтгэл						
15	Зохиогчийн хяналтын зардал	төлөвлөгөө	86 623	140 940	123 889	162 264	90 405	620 061
		гүйцэтгэл						
16	Магадлашгүй ажил	төлөвлөгөө	173 246	281 880	247 778	324 528	180 810	1 240 122
		гүйцэтгэл						
17	Инженер, хайгуул зураг төсвийн үнэ	төлөвлөгөө	2 400 000					2 400 000
		гүйцэтгэл						
18	Улсын комисст хүлээлгэн өгөх	төлөвлөгөө	9 981 821	16 237 209	16 669 559	18 674 102	10 417 099	73 818 653
		гүйцэтгэл						

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН  
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА,

Б.ДОЛЖИНСОРОГ ДОГ

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,  
Аймгийн ЗДТГ-ын "А" байр  
Утасны дугаар: 99058438  
70388849

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“БУНБАХ” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕР

Б.БАТСАЙХАН

Хөвсгөл аймаг, Мөрөн сум  
7 дугаар баг  
Утас:99993240,99998923

Захиалагчийг төлөөлж: \_\_\_\_\_

Гүйцэтгэгчийг төлөөлж: \_\_\_\_\_



БШУЯ/202102171/1.4.2 дугаартай  
гэрээний 5 дугаар хавсралт

**БАРИЛГЫН АЖИЛД АШИГЛАХ МОНГОЛ УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ГАРАЛ ҮҮСЭЛТЭЙ БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ  
ХИЙЩИЙН ЖАГСААЛТ**

№	Материалын нэр, марк	Барилгын материалын техникийн тодорхойлолт, холбогдох стандарт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төгрөг/ Бүгд үнэ /төгрөг/
1	Хөвөө мод	МУ-ын стандартад нийцсэн	м	478,5	1300 622077
2	Үртэс	МУ-ын стандартад нийцсэн	м 3	56,1	7000 392700
	Дүн				1,014,777

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН  
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА,

Б.ДОЛЖИНСОРОГ ДОГ

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,  
Аймгийн ЗДТГ-ын "А" байр  
Утасны дугаар: 99058438

70388849

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“БУНБАХ” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕР

Б.БАТСАЙХАН

Хөвсгөл аймаг, Мөрөн сум  
7 дугаар баг  
Утас: 99993240, 99998923

Захиалагчийг төлөөлж: \_\_\_\_\_

Гүйцэтгэгчийг төлөөлж: \_\_\_\_\_




**САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ**

№	Ажлын нэр	Гэрээний дүн /төгрөгөөр/	2021 он		Дүн
			6-р сар	7-р сар	
1	Корунда будгаар шал будах	73 818 653	1 759 163		1 759 163
2	Хулдаас нааж шал хийх		9 468 041		9 468 041
3	Гадна хана базалтаар дулаалах		9 278 102		9 278 102
4	Хучилтын термолиттой шаар зуурмагаар дулаалах		5 956 483		5 956 483
5	Радиатор угсрах		8 712 573		8 712 573
6	400мм голчтой деплектор угсрах		654 502		654 502
7	Хүүхдийн шээлтүүр байрлуулах		939 870		939 870
8	Халаалтын ган яндангууд угсрах		1 515 850		1 515 850
9	Фланц д-25мм байрлуулах		446 745		446 745
10	Далд залгуур тавих, цахилгааны утас сүвлэх, хуанцар хоолой тэдгээлдэжугсрах, ховил гаргах			3 000 233	3 000 233
11	Хана, таазыг эмульсээр будах			23 267 371	23 267 371
12	Анги, унтлагын өрөөний шалыг резинэн будгаар будах			1 560 252	1 560 252
13	Анги, унтлагын өрөөний ханыг корунда будгаар будах			1 759 163	1 759 163
14	Захиалагчийн хяналтын зардал		702 904	537 218	1 240 122
15	Зохиогчийн хяналтын зардал		351 452	268 609	620 061
16	Магадлашгүй ажил		702 904	537 218	1 240 122
17	Инженер, хайгуул зураг төсвийн үнэ		2 400 000		
Ажлын гүйцэтгэл /хувиар/			58.1%	41.9%	100%
Санхүүжилтийн дүн /хувиар/			58.1%	41.9%	100%
Санал болгож буй санхүүжилтийн дүн			42 888 589	30 930 064	73 818 653

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН  
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА,

 Б.ДОЛЖИНСОРОГ ДОГ


Хөвсгөл аймаг, Мөрөн сум,  
Аймгийн ЗДТГ-ын "А" байр  
Утасны дугаар: 99058438

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"БУНБАХ" ХХК-ИЙН ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕР

 Б.БАТСАЙХАН

Хөвсгөл аймаг, Мөрөн сум  
7 дугаар баг  
Утас: 99993240, 99998923

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 